



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар М/104

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 28 дугаар дүгнэлтийн дагуу Хог тээврийн автомашин (Өвөрхангай) БХБЯ/202001172 нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 521.610.000 (таван зуун хорин нэгэн сая зургаан зуун арван мянга) төгрөгөөр Нутгийн буян групп ХХК-иар нийлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100245

D: My Doc. Tushaal. ZDTG